



2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

СААДГҮЙ ОРЧИН, ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)-д “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй” (13 дугаар зүйл), “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй” (22 дугаар зүйл), “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй” (23 дугаар зүйл), “Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй” (25 дугаар зүйл), “Хүн бүр сурч боловсрох эрхтэй” (26 дугаар зүйл), “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй” (27 дугаар зүйл) гэж тус тусзаасан байна.

Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)-ыг соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 1976 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Уг Пактаар Оролцогч Улсууд “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүйгээр эрхээ эдлэх” (2 дугаар зүйл), “хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээний түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө (11 дүгээр зүйл) гэж заасан байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ЭСКАП)-оос бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хөгжлийг дэмжих зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ази, Номхон далайн бүсийн Арван жилийн төлөвлөгөөг зарладаг бөгөөд 2023-2032 онд Жакартагийн тунхаглалын гуравдугаар зорилго нь: “Биет орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцааны хүртээмжийг

сайжруулах” ба Монгол Улс 2032 онд тухайн асуудлаар хүчин чармайлт гаргаж, тайлан хүргүүлэх үүргийг хүлээсэн.

Түүнчлэн НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” буюу дэлхийн хөгжлийн зорилтуудын 10 дахь “Тэгш бус байдлыг бууруулах”¹ зорилтын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих”², мөн “Ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халж, энэ талын хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар тэгш боломж бололцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах”³, “Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”⁴ үүргийг хүлээсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.” гэж заасан бөгөөд түүнийг хууль тогтоомжоор баталгаажуулах шаардлагатай.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” хэмээх Хоёрдугаар бүлгийн Хүнд ээлтэй амьдрах орчин Зорилт 2.5.2-ийн 1 дэх заалтад “Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгоно.” гэж, “Хүн, нийгмийн амар тайван байдал” хэмээх бүлгийн Зорилт 7.3.Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ. гэж, “Хүн төвтэй хот” хэмээх бүлгийн Зорилт 9.1-ийн 1 дэх заалтад “Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.” гэж тус тус тусгасан.

Олон улсын стандартын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн Дижитал хүртээмж, Веб контентын хүртээмжийн удирдамжийг 2019 онд Монгол хэлнээ хөрвүүлж, олон нийтэд хүргэсэн бөгөөд Засгийн газрын 2022 оны 201 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын 2.1-д “Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан өөрт хамаарах нээлттэй мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж, “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага” Монгол Улсын MNS 6285:2017”

¹ Тогтвортой хөгжлийн зорилго

² Мөн тэнд Зорилт 10.2

³ Мөн тэнд Зорилт 10.3

⁴ Мөн тэнд Зорилт 10.4

стандартыг хангасан, Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1)-д нийцсэн өөрийн цахим хуудас (цаашид "цахим хуудас" гэх)-д байршуулж нийтэлнэ" гэж журамласан боловч хууль тогтоомжид тусгагдаагүй.

УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн Хоёрдугаар бүлэгт Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. ", 2.1.4.1.Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна., 2.2.1.4.Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно., 2.3.2.2.Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж тус тус тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл⁵"-ийн 98-д ... хүний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн, бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах, барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор "Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл"-ийг 2025 онд боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан.

Саадгүй орчин, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан тайлангийн дүгнэлтээс үзвэл Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг бусад салбарын хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан байдаг ч хүний бие даан саадгүй ажиллаж, амьдрахад шаардлагатай дэд бүтцийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд тавих шаардлагуудтай тэр бүр нийцэхгүй, хоорондоо уялдаа холбоогүй байна гэж дүгнэжээ.

Иймд тухайн харилцааг зохицуулсан анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзлээ. Хуулийн төслийн нэрийг гадаадын зарим орны хүртээмж, саадгүй орчны талаарх хууль тогтоомжийг харьцуулсан судалсны үндсэн дээр "Саадгүй орчин, хүртээмжтэй үйлчилгээний тухай" гэж өөрчилж боловсруулна.

1.2.Практик шаардлага

⁵Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392437841&showType=1>

Монгол Улсад өнөөдөр 112 мянга гаруй (нийт хүн амын 3.5 хувь орчим) хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаагаас 2023 оны байдлаар 3 хүн тутмын 1 нь буюу 35 мянга гаруй⁶ хөгжлийн бэрхшээлтэй хүн нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 35 орчим хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй буюу таяг, тэргэнцэр хэрэглэдэг, 15 орчим хувь нь харааны бэрхшээлтэй, 12 орчим хувь нь сонсголын бэрхшээлтэй байна.

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 170 мянга гаруй осол, гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 2023 оны байдлаар 601,4 байна. Нийт осол гэмтлийн 89,9 хувийг санамсаргүй байдлаар үйлдэгддэг осол, гэмтэл эзэлж байгаагаас тэргүүлэх шалтгаанд унах, амьгүй механик хүчин зүйлд өртөх, зам тээврийн осол тооцогдож байгаа ба үүний үндсэн гол хүчин зүйлийн нэг нь хүрээлэн буй орчны саад бэрхшээлээс болжээ.⁷

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны бүс, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам нь стандартын шаардлага хангаагүйгээс хүүхэд бэртэж гэмтэх, бие даан аюулгүй зорчих эрх нь зөрчигдөх гол шалтгаан болж байна. Мөн Монгол Улсад 320 мянга гаруй ахмад настан, жилд ойролцоогоор 75 мянга орчим жирэмсэн эмэгтэй, 2 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эмэгтэй ойролцоогоор 50-55 мянга орчим, хүүхдээ тэргэн дээр түрж байгаа нийт эцэг эхийг оролцуулаад 100 гаруй мянган хүн байна. Ингээд тооцвол саадгүй орчин, хүртээмж шаардлагатай 450 мянга гаруй хүн Монгол Улсын хэмжээнд байна.

Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эх, хүүхдээ асарч буй эх, эцэгт нийгэм, эдийн засаг, соёлын эрхээ бусдын нэгэн адил бүрэн дүүрэн эдлэхэд, төрийн үйлчилгээг саадгүй хүртэхэд саад бэрхшээлүүд тулгарсаар байна. Тэдгээрийн зарим нэг гол шалтгааныг судлан үзвэл барилга, байгууламж, зам, тээвэр, мэдээллийн дэд бүтэц хангалтгүй, төрийн үйлчилгээ хүртээмжгүй байна. Энэ нь тэдэнд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, бусдын нэгэн адил нийгмийн харилцаанд оролцох, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд хязгаарлагдмал нөхцөл байдал үүсгэж бэрхшээлийг улам нэмэгдүүлж байгаагаас бие даан амьдрах эрх нь зөрчигдөн хэн нэгнээс эрх чөлөө, эдийн засгийн хувьд хараат амьдрахад нөлөөлж байна.⁸

Монгол Улсад 6525 стандарт үүнээс барилга байгууламжид хамааралтай 655, хүрээлэн буй орчинтой холбоотой 235 стандарт, хотын 20 орчим стандарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд хүн, хуулийн этгээдээс стандартыг дагаж мөрдөхгүй үйл ажиллагаа эрхэлж, үйлчилгээ үзүүлдэгээс шалтгаалж хүний эрүүл мэнд хохирох, амьдрах орчин нөхцөл алдагдах зэрэг олон сөрөг үр дагаврууд гарч байгааг судалгаануудад дурджээ.⁹

⁶Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйс, бүс, аймаг, нийслэлээр. Эх сурвалж: <https://www2.1212.mn>

⁷ Монгол Улсад бүртгэгдсэн осол, гэмтлийн тархвар зүйн судалгаа 2019-2023 он.

⁸ Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох тандан судалгаанаас. 2025 он.

⁹ /Стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа 2024 он/

Барилга, байгууламж, зам, тээврийн дэд бүтцийн хувьд:

1/Барилга байгууламж, дэд бүтэц саадгүй орчин, хүртээмжийн шаардлага хангахгүй байна. Монгол Улсад төрийн үйлчилгээ үзүүлдэг цэцэрлэг, сургууль, эмнэлэг, халамж, хөдөлмөр, бүртгэл, нийгмийн даатгал, соёл, спорт г.м. байгууллагыг хамруулаад нийт 6000 орчим байгууллага байна. Үүнээс сургууль, цэцэрлэг 1600 орчим, эмнэлэг, эрүүл мэндийн төв 2200 орчим, Халамж, нийгмийн даатгал, хөдөлмөр, бүртгэлийн буюу иргэнд шууд үйлчилгээ үзүүлэгч 400 орчим, Нэгдсэн төрийн үйлчилгээний төвүүд буюу нэг цэгийн үйлчилгээний төвүүд 50 орчим, аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, ЗДТГ 1700 орчим, яам, агентлаг 100 орчим, бусад (татвар, мэргэжлийн хяналт, цагдаа) 500 орчим, соёл, спорт номын сан 300 орчим байгууллагууд байна. Дээрх төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд 85 хувь нь хуучирсан барилгад байрлан үйл ажиллагаа явуулдаг ба саад бэрхшээлийг арилгаагүй, ажлын байрны тохируулга хийгдээгүй, үйлчилгээ хүртээмжгүй байдаг.

Түүнчлэн, нийслэл Улаанбаатар хотын хувьд хот төлөвлөлт алдагдаж, өмнө баригдсан болон шинээр баригдаж буй олон нийтийн зориулалттай барилга байгууламж, авто болон явган хүний замын байгууламж, гудамж, зам талбай холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, нормативын шаардлага хангахгүй байна.

2/Аймаг, хотод явган хүний замын хүртээмж (тэргэнцэртэй хүн, хараагүй хүн, хүүхэдтэй ээж, өндөр настан зэрэг бүх хүний аюулгүй, саадгүй зорчих боломж) нь нийтлэг хангалтгүй байдалтай байна. Ялангуяа Улаанбаатар болон аймгийн төвүүдэд явган хүний зам байгаа ч хүртээмж муу, стандарт мөрдөлт хангалтгүй байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын 19 чиглэлд 98 км явган хүний замд 4 шалгуур үзүүлэлтээр хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн үйлчилгээний хүртээмжид үнэлгээ¹⁰ хийхэд явган хүний замын 80 хувь, харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хөтөч замын 90% нь стандартын шаардлага хангаагүй, нийт 98 км явган хүний зам дээр ТҮЦ, зам руу түрж барьсан барилга, траншейны таг, зар, реклам сурталчилгаа зэрэг 109 саад байршуулсан судалгааны үр дүн, мөн 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцох идэвх, оролцоог тандсан судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2,36% нь өөрөө оролцох сонирхолгүй, 27,6% нь нийгмийн харилцаа, хандлага, 80,0% нь зам, шат, хаалга, 98% хувь нь тээврийн хэрэгсэл, унаа гэсэн хариулт¹¹ өгсөн үр дүнгээс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаан бол орчны саад, хүртээмжгүй байдал болохыг харж болно.

¹⁰ ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/183 дугаар тушаалаар 3-н салбарт хүртээмжийн үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг ЖАЙКА олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төслийн хүрээнд хийжээ. .

¹¹ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

3/Гэрлэн дохио, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээ хүртээмжгүй байна. Нийслэлийн хэмжээнд 2025 оны байдлаар үйлчилгээнд явж буй нийтийн тээврийн 1200 автобусаар үйлчлүүлж байна. Үүнээс налуу замтай, доод шалтай буюу шатгүй автобус 150-200 орчим, тусгай суудалтай/тэргэнцрийн бэхэлгээтэй 15-20 автобус байна. Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН, жолооч нарын саадгүй орчны талаарх ойлголт мэдлэг хангалтгүй, үүнээс үүдэлтэй гэмтлийн эрсдэл нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, нийт тээврийн хэрэгслийн 10 орчим хувь нь хүртээмжтэй байгаа нь нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг зөрчих нэг нөхцөл болжээ.

Мэдээллийн хүртээмжийн хувьд:

4/Төрийн байгууллага, аж ахуйн нэгжээс олон нийтэд чиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ буюу хаягжилт, угтах үйлчилгээ, цахим хуудас, телевиз, цахим болон зайны үйлчилгээ, тэдгээрт хэрэглэгдэж буй техник технологи, программ хангамж зэрэг нь хүртээмжгүй байна. Тухайлбал, цахим технологи ашиглах мэдлэг, чадвар дутмаг, гадаад хэлний бэрхшээл, дата худалдаж авах санхүүгийн хүндрэл, сайтын агуулгыг уншихад бэрхшээлтэй буюу үсэг нь томордоггүй, сүлжээтэй газар хайх зэрэг бэрхшээлүүдийг судалгаанд дурджээ. Төрийн үйлчилгээг цахимаар авахад веб, аппликейшны дэлгэцийн харагдах байдал ойлгомжгүй, үсэг томруулах үйлчилгээ, үсэг томруулах хулгана байхгүй, сонгосон текстийг дуу хоолойгоор унших боломжгүй зэрэг үйлдлийн систем байхгүйн улмаас цахим үйлчилгээг авахад хязгаарлалт үүсэж байна.¹²

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас (тухайн үеийн нэршлээр) 2016 онд хийсэн мэдээллийн хүртээмжийн үнэлгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээ, мэдээлэл түгээдэг сувгуудын 97 хувь нь хүртээмжгүй байсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын байдлаар Монгол Улсын Засгийн газрын харьяа 14 яамны цахим хуудаснууд¹³ харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байгаа бол олон нийтийн хэвлэл мэдээллийн цахим хуудаснууд мөн адил хүртээмжгүй, төрийн байгууллагаас гарч буй тушаал, тогтоол, хууль, дүрэм журам хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжгүй байсаар байна, зөвхөн бичвэр хэлбэрээр мэдээллийг гаргаж байна. Монголын хараагүйчүүдийн холбооноос “веб контентын хүртээмжийн удирдамж” (WCAG 2.1)-ийн дагуу 48 шалгуур үзүүлэлтээр төрийн болон хувийн хэвшлийн веб хуудсыг шинжлэхэд бүгд шалгуур үзүүлэлтэд үл нийцсэн байна гэжээ.^[1]

Иймд компьютер, гар утас, цахим ном уншигч төхөөрөмж, банкны автомат, карт уншигч төхөөрөмж, вэбсайт болон гар утасны аппликейшнүүд, цахим худалдаа, тээврийн үйлчилгээний мэдээлэл (тасалбарын автомат, цахим үйлчилгээ гэх мэт), нийтийн хэрэглээний онцлог бүхий биет болон биет бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн үйлдвэрлэл, хөгжүүлэлт, худалдаа, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй

¹² Төрийн цахимжилтын үр ашгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүртэж буй байдал, цахим хуваагдлын судалгааны тайлан. Хүний эрхийн үндэсний комисс, Тэгш нийгэм холбоо ТББ, 2025 он

¹³ Яамдын цахим хуудасны хүртээмжтэй байдлыг <https://mongolia.gov.mn/холбоосоор> орж шалгасан.

хүнд хүртээмжтэй, хүргэх төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай байна.

5/Туслах технологийн хэрэгцээ: Хүн бүрийг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан бие даан амьдарч, бусдаас хараат бус байхад туслах гол зүйл бол туслах бүтээгдэхүүн юм. Монгол Улсын нийт хүн амын 15.1 хувь (490 мянган хүн)-д туслах технологи хэрэгтэй байгаа бөгөөд 11.5 % (373 мянган хүн) ямар нэг туслах бүтээгдэхүүн хэрэглэж байгаагаа зөвхөн 7.5 хувь (243 мянган хүн) хэрэгцээ нь хангагдсан, 7.7 хувь (247 мянган) хэрэгцээ нь хангагдаагүй байна.¹⁴

6/Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд холбогдох бүхий л олон улсын бичиг баримтыг мэдэж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настнуудыг төрийн үйлчилгээг амар, хялбар авч, бие дааж, аятай тухтай амьдрах тал дээр нэг ч дорвитой алхам хийгээгүй байна. Төрийн үйлчилгээг цахимжих явцыг тодорхой түвшинд хийж байгаа боловч эмзэг бүлэгт тооцогддог, үйлчилгээ нэн шаардлагатай иргэд, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрхийг тунхагласан хэвээр, үйлчилгээг хүн ойртуулах ажиллагаагүй хийгээгүй байна. 2021 онд ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэй “Туслах технологийнхоо хэрэгцээг” гаргасан боловч Туслах технологийн стратегиа батлаагүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон ахмад настнуудад олгодог туслах бүтээгдэхүүнүүд нь наад захын нэн шаардлагатай бүтээгдэхүүнүүдийг олгодоггүй нь Нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалтыг ДЭМБ-ын жагсаалтын дагуу гаргаагүй нь харагдаж байна. “Туслах технологи”-ийн тухай ойлголт төрийн байгууллагат байхгүй байгаа нь энэ талаар ямар нэгэн ажил хийгээгүй байгаагаар харагдаж байна. Тиймээс төрийн үйлчилгээ бүхэлдээ хүртээмжийг хангаагүй, “түгээмэл загвар”-ыг бий болгох нэг ч ажил хийгдээгүй байна.¹⁵

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагад тулгуурлан цаашид саадгүй орчинг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн чиг үүргийг тодорхой болгож, мэргэжлийн холбоо, хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн оролцоог дэмжих замаар хүний нийгэм, соёлын эрхийг баталгаажуулах шаардлагатай гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1.Монгол Улсын хөгжлийн баримт бичигт дурдсан стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, хүний хөгжлийг дэмжих, ая тухтай орчин нөхцөлд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулах ба хуулийн

¹⁴ Монгол Улс 2021 онд Туслах технологийн түргэвчилсэн үнэлгээ - ДЭМБ-ын аргачлалаар “Туслах технологийн хэрэгцээг тодорхойлох нь” өрхөд суурилсан түүвэр судалгаа. (нийт 10 мянган хүн амд хийсэн судалгаа)

¹⁵ “Цахим хөгжлийн хүртээмж, төрийн цахим үйлчилгээний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнуудад чиглэсэн хүртээмж, туслах технологи, цахим технологийн бодлого, зохицуулалт”. Бодлогын судалгаа. Хүний эрхийн үндэсний комисс, Тэгш нийгэм холбоо ТББ, 2025 он

төслийн нэрийг "Саадгүй орчин, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх тухай" гэж томъёолно.

2.2.Саадгүй орчин, хүртээмжтэй үйлчилгээний тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын баримт бичиг, конвенцын шаардлагад нийцүүлэн шинээр тусгана.

2.3.Саадгүй орчныг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг хангаж, төрийн хяналтыг хэрэгжүүлэх, тогтолцоо, процессыг оновчтой тодорхойлно.

2.4.Саадгүй орчныг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүний амьдрах орчныг сайжруулах, олон талын оролцоог тусгасан тусгайлсан зохицуулалт хийж, салбар дундын бодлогоор шийдвэрлэх, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагын бүрэн эрх, үүрэг, оролцоог тодорхойлох, хүртээмжийн үнэлгээ хийх талаар тусгана.

2.5.Барилга байгууламж, дэд бүтэц, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээнд саадгүй орчныг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд бие даан оролцох эрхийг хангахад чиглэсэн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ;

2.6.Хуулийн төслөөр хүн бүр, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, жирэмсэн эх, хүүхэд, 0–3 насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, түр хугацаагаар хөдөлгөөн хязгаарлагдсан иргэн төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг саадгүй орчинд амьдрах, үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, аюулгүй, нэр төртэйгөөр авах эрхийг хангаж, орчны саад, эрсдэлийн талаар мэдээлэх, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх талаар тусгана.

2.7.Хуулийн төсөлд хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажуулж, хот төлөвлөлт, хүний амьдрах орчныг саадгүй орчин бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж түүнийг хэрэгжүүлэх механизм, хяналт, хариуцлагын тогтолцоог тодорхой заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үндсэн чиг үүрэг болох хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, саадгүй орчинг бүрдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжрах ба төрийн байгууллага, албан тушаалтны эрх үүрэг тодорхой болж, хуулийн болон чиг үүргийн давхардал, хийдэл арилна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй 70 гаруй мянган иргэний эрхийг хангахад чухал нөлөө үзүүлэхээс гадна 0-9 насны 725 мянга гаруй, 65-аас дээш насны 320 мянга орчим иргэн, 5 мянга орчим жирэмсэн эмэгтэй, 2 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эмэгтэй ойролцоогоор 50-55 мянга орчим иргэн хуулийн үйлчлэлд

хамрагдаж, төрийн үйлчилгээ хүртээмжтэй болж, дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжээс Монгол Улсын бүх иргэн ашиг хүртэж, “түгээмэл загвар”-ыг нэвтрүүлнэ.

Хүртээмжийн үнэлгээ хийх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хүртээмжийн чиглэлээр мэргэшсэн холбоо, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж, гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоо бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй, улсын төсөвт ачаалал үүсэхгүй бөгөөд харин хүртээмжийн чиглэл бүрээр хүний нийгэм соёлын эрхийг эрхийг хангахад чиглэсэн үндэсний стандарт, дүрэм журмуудыг шинээр батлах, шинэчлэх хэрэгцээ шаардлага үүснэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулна.

1/барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

2/авто зам, замын байгууламж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

3/мэдээллийн технологи, харилцаа холбоо болон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

4/хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Ахмад настны тухай, Боловсролын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан

тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

Дээрх дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахдаа "түгээмэл загвар"-ын стандартыг хуульчлах, хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн харилцаанд бие даан, аюулгүй оролцох хэрэгцээнд тулгуурлан барилга байгууламж, зам тээвэр, мэдээлэл харилцаа холбооны хүртээмжийн шаардлагыг хангаагүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тодорхой болгоно.

---o0o---